

**Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн ҮЗЗ-ийн гишүүд
“Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ерөнхий газрын харьяа хорих 429-р анги, Монголын улаан загалмайн нийгэмлэг”
зэрэг байгууллагуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцсан ажлын тайлан**

Хугацаа: 2017 оны 11 сарын 24-ний Баасан гариг

Хамрагдсан газрууд:

1. Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 429-р анги
3. Монголын улаан загалмайн нийгэмлэг

Ажилласан бүрэлдэхүүн:

1. Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга
2. А.Нямдорж, ҮЗЗ-ийн дэд дарга
3. Н.Тамир, ҮЗЗ-ийн гишүүн
4. Б.Мөнхбаяр, ҮЗЗ-ийн гишүүн
5. Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын алба

Зорилго:

Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 429-р анги, Монголын улаан загалмайн нийгэмлэг зэрэг байгууллагуудад Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах явдал байлаа.

Энэхүү үйл ажиллагааны зорилтын хүрээнд үр ашиг, үйл ажиллагааны асуудал (хэрэгжилт, техникийн, захиргааны, санхүүгийн), үр дүн болон үр нөлөөг үнэлэлээ. Ажлын баг нь шаардлагатай зөвлөмжүүдийг өгөх болон бусад байгууллагуудын хувьд ашигтай байж болох саналыг авч, байгууллагуудын хэрэгцээ, шаардлага, төслийн тогтвортой байдал төслийн ач холбогдлыг үнэлсэн болно.

Аргачлал:

Ажлын баг жишиг баримт бичиг, асуумж, мэдээлэл түгээлт, материал, гол мэдээллийн эх сурвалжийг хянаж, эмч мэргэжилтэнгүүдтэй ярилцлага хийн асуумж бөглөж, албан болон албан бус хэлэлцүүлгийг зочилсон газрууддаа хийж гүйцэтгэсэн болно.

Монголын улаан загалмайн нийгэмлэг

Уулзсан хүмүүс:

1. Н.Болормаа, МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн дарга
2. Б.Даваажав, МУЗН-ийн хөтөлбөр хамтын ажиллагааны газрын дарга
3. н.Уугантуяа, МУЗН-ийн эрүүл мэндийн хөтөлбөрийн ажилтан
4. Б.Гантулга, МУЗН-ийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зөвлөх

Ерөнхий мэдээлэл:

“Гэр оронгүй иргэдийн дунд сүрьеэгийн эрт илрүүлэлт, эмчилгээ, хяналт, нийгмийн дэмжлэг” төслийг 2017 оны 1 сараас тус оны 12 сар хүртэл 12 сарын хугацанд

хийж хэрэгжүүлэх. Тусламж хүртэх хүний тоо 3000, хамрах хүрээ-Улаанбаатар хотын долоон дүүрэг.

САНХҮҮ: Төслийн гэрээг орой хийсэн учраас эхний санхүүжилт 2 дугаар улиралд шилжин орж ирж 2017 оны 5 дугаар сараас үйл ажиллагааг эхлүүлсэн.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Ариун цэврийн багцыг хэвтэн эмчлүүлж буй өвчтөнгүүдэд олгодог. Сайн дурын идэвхитэнгүүдэд сард 75000 төгрөгийн урамшуулал олгодог.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Орон гэргүй иргэдийн дунд Сүрьеэгийн идэвхитэй илрүүлгийн дүн:

870	-	37	тохиолдол
700	-	5	тохиолдол
730	-	13	тохиолдол

Нийт- 21 удаагийн үзлэгээр 2300 хүнийг үзлэгт оруулж Сүрьеэгийн 55 тохиолдлыг илрүүлээд байна.

Сүрьеэгийн идэвхитэй үзлэгээр 7 дүүрэгт нийт давтагдсан тоогоор 315 хүн ажилласан. Нэг үзлэгт ойролцоогоор 120 хүнийг үзлэгт хамруулдаг ба дунджаар 30-50 сайн дурын идэвхитэн, Энэрэл эмнэлэг болон Цагдаагийн байгууллагын ажилчид оролцдог. Үзлэг болгоны өмнө Сүрьеэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдолын тухай сургалт хийдэг. Үзлгийн үеэр сүрьеэгийн онош илэрсэн өвчтөнг Энэрэл эмнэлэг рүү шилжүүлдэг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүү чиглэсэн үйл ажиллагаа сайн явагддаг. Тус үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх нь нэн ач холбогдолтой.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал сар бүр хийгддэг.

БЭРХШЭЭЛ:

- Орон гэргүй хүмүүсийг олоход цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах нь зарим хүмүүст буруу хардлага сэрдлэгэ төрүүлдэг;
- Үзлэг хийх байрны асуудал тэр дундаа өвлийн улиралд хүндрэлтэй. Байр олдохгүй эсвэл тухайн өрхийн эмнэлэгт үзлэг хийх зөвшөөрлийг дүүргийн засаг даргаас авахад өрхийн эмнэлэг татгалзаж ажилд саад учруулдаг;
- ХӨСҮТ болон Энэрэл эмнэлэгийн уялдаа холбоог сайжруулах.


САНАЛ:

- Сүрьеэ өвчинд хандах хандлагыг өөрчилж олон нийтэд хандсан сургалт зохион байгуулж, мэдлэг олгох явдал нэн чухал. Орон гэргүй хүмүүс рүү хандсан Төрийн байгууллага тэр дундаа ЭМ-ийн байгууллагын хандлага сул нь ялгаварлан гадуурхалтыг бий болгож байна.

- Одоогийн орон гэргүй хүмүүстэй хийж буй үйл ажиллагааг улам өргөжүүлж нийгмийн сэтгэл зүйн дэмжлэгийг түлхүүр хүн амд үзүүлэх шардлагатай.
- Нийгмийн халамжийн хөтөлбөр манай улсад дутагдалтай байна. Бичиг баримтжуулах, халамжийн бүртгэлийн асуудалд анхаарлаа хандуулан ажиллах.
- Сүрьеэгийн эмчилгээ үйлчилгээг цагдаагийн байгууллагаар албадуулан хүлээн авах бус өөрөө өөрсдийгөө гэгээрүүлж, бие биедээ нөлөөлүүлж сургах шаардлагатай байна.

ҮЗЭ-ИЙН ЗӨВЛӨМЖ:

- ҮЗЭ-ийн баг хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын хүрээнд дараагийн удаа үзлэг, шинжилгээ хийж байх үеэр очин үйл ажиллагаатай танилцах;
- Сургалт сурталчилгааны үйл ажиллагааг нэмгдүүлэх боломжийг эрэлхийлэх;
- Дүүргийн засаг дарга нарыг тус ажилд татан оролцуулж тэдний оролцоог нэмэгдүүлэх;
- Peer to peer үйл ажиллагаа (нийгмин бүлэг дундаа бие биендээ нөлөөлөх)-г дэмжих.



Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам

Уулзсан хүмүүс:

1. С.Ариунаа, БСШУСЯ-ны албан болон албан бус сургалтаар ХДХВ/ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Ерөнхий мэдээлэл: “БСШУСЯ-ны албан болон албан бус сургалтаар өсвөр үе, залуучуудад ХЗДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх боловсрол олгох” хөтөлбөр нь 2015 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл

хэрэгжүүлхээр БСШУСЯ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Улмаар БСШУСЯ тус төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлхээр гэрээт ажилтанг сонгон шалгаруулсан байна. Гэрээт ажилтан С.Ариунаа нь төслийн санхүүжилтээр цалинждаг ба хөдөлмөрийн гэрээг БСШУСЯ-ны Статистик Бодлого Төлөвлөлтийн газартай байгуулсан.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Үйл ажиллагааны чиглэл:

1. Багшийн гарын авлага, эмхэтгэл боловсруулах;
2. Эрүүл мэндийн багш нарыг сургах;
3. Хөдөө орон нутгийн багш нарыг сургах;
4. Сургуулийн удирдлагуудад нөлөөллийн ажил зохион байгуулах;
5. Үе тэнгийн сургагч нарт зориулсан гарын авлага боловсруулах;
6. Нийслэлийн ЕБС (Ерөнхий Боловсролын Сургуулийн)-иудад үе тэнгин сургагч бэлдэх;
7. Хөдөө орон нутагт үе тэнгийн сургагч бэлдэх;
8. Сургагч нараар дамжуулан хяналт тавих.

Нийт үйл ажиллагааны 85% нь биелэгдсэн ба төслийн хугацаа дуусгавар болоход 100%-ийн биелэлттэй байхаар төлөвлөж байна.

САНХҮҮ: Санхүүжилтийг БСШУСЯ-ны Төрийн сангийн дансаар шилжүүлэн хүлээн авдаг. Төр засаг солигдсонтой холбогдуулан төслийн үйл ажиллагаа 2016 оны 07 дгаар сараас 12 дугаар сарын хугацаанд түр саатсан. Гэсэн хэдий ч зорилтот үйл ажиллагаануудыг шахан хугацаанд нь багтаан хийж гүйцэтгэсэн болно.

Төслийн нийт санхүүжилт 109,834 ам.доллар ба одоогийн байдлаар ойролцоогоор 136 сая төгрөгийг зарцуулсан ба төслийн хугацаа дуусгавар болоход санхүүжилт хэмнэгэх төлөвтэй байна.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Гарын авлага, эмхэтгэл.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Үе тэнгийн сургагч нараар дамжуулан сурагч хүүхдүүд нөхөн үржихүйн мэдлэг, мэдээллийг хүлээн авах боломжтой болсон. Мөн нийслэл хот төдийгүй хөдөө орон нутгийн багш нарыг бэлдсэнээр хүсээгүй жирэмслэлт, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх болсон нь сайшаалтай хэрэг юм. Төслийн хүрээнд 2017 онд нийслэлд 558, орон нутагт 649, нийтдээ 1207 үе тэнгийн сургагч, 327 багш нарыг сургаж, нийт 280 сургуулийн 165 удирдлагуудад нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ: ЕБС-иудын хичээлийн хөтөлбөрөөс эрүүл мэндийн цагийг хассан явдал нь сурагч хүүхдүүд эрүүл мэндийн холбогдолтой мэдээллийг хүлээн авах урсгал хаагдсан. Биеийн тамирийн хичээлийг эрүүл мэндийн цагтай уялдуулсан нь учир дутагдалтай ба биеийн тамирийн багш нар эрүүл мэндийн хичээлийг заадаггүй байна. Иймд багш нарыг бэлдэх, одоогийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үргэлжлүүлэх нь нэн чухал асуудал болж байна.

ҮЗЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ:

- ҮЗЗ эрүүл мэндийн хичээлийн цагийг нэмж оруулах талаар БСШУСЯ-нд нөлөөлж, ГС-гийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг танилцуулж, одоогийн хийгдэж буй үйл ажиллагааны тогтвортой байдлыг цаашид хангах чиглэлээр БСШУСЯ-нд хандах;
- Одоогийн хийгдэж буй үйл ажиллагааны залгамж халааг үргэлжлүүлэх бодлогын арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх;
- Төслийн хэмнэгдсэн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 429-р анги Уулзсан хүмүүс:

1. Д.Дамдинцэрэн, хурандаа

Ерөнхий мэдээлэл: Монгол улсын хэмжээнд 24 хорих, 22 цагдан хорих байр (урьдчилан хорих байр) үйл ажиллагаа явуулж байгаа тэдгээрт өнөөдрийн байдлаар 2963 хоригдол, цагдан хоригдож буй 8668 хоригдогч байна. ШШГЕГ-ын харьяа 429-р хаалттай хорих анги-төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь улсын хэмжээнд хорих ял эдэлж байгаа болон урьдчилан хоригдож байгаа этгээдүүдэд сүрьеэ өвчнийг оношлох, урьдчилан сэргийлэх, сувилах, диспансерийн хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэж байна. Тус ангийн эмнэлэг нь сүрьеэгийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг 60 ортойгоор үзүүлэх зөвшөөрөлтэй ажилладаг. **“Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх,**

эмийн дасалтай сүрьеэгийн аюулд анхаарал хандуулах” төслийг 2016 оны 07 дугаар сарын 1-нээс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэх гэрээтэй ажиллаж байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэлт, урьдчилсан сэргийлэх үзлэг, рентген шинжилгээ, цэрний түрхэцийн шинжилгээ зэргийг тогтмол хийж гүйцэтгэснээр хоригдлуудын дунд сүрьеэгийн тархалтыг тогтоон барихад чухал ач холбогдолтой. Хорих ангийн эмч мэргэжилтнүүд болон алба хаагчдад сургалт сурталчилгаа хийснээр эмчилгээний үр дүнд эерэгээр нөлөөлж, өвчний талаар зөв ойголттой болдог. Сүрьеэгийн өвөрмөц эмчилгээтэй хоригдлуудад нэмэгдэл хоол хүнсийг олгож байгаа ба давхардсан тоогоор 22800 хүн, Биот уургийг нэг хүнд 30 граммар тооцон өдөр бүр олгосноор давхардсан тоогоор 5600 хүнд нэмэгдэл хүнсээр өгсөн байна. Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчтөн эмчлэх тасагт урсгал засвар хийж агааржуулалтын системийг стандартын дагуу болгосон.

САНХҮҮ: Санхүүжилтын тайланг тухайн сарын сүүлээр илгээснээр дараа сарын санхүүжилт саадгүй орж ирдэг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Биологийн аюулгүй шүүгээ, флюорографийн аппарат, цахилгаан микроскоп, 4 ширэмтэй плитка, брусан хөргөгч, электрөн жин, сорьц зөөвөрлөх хөргөгч зэрэг тоног төхөөрөмжөө хангасан. Эмэнд мэдрэг болон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмийг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албанаас 3 сараар нөөцлөн авдаг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Сүрьеэгийн эмчилгээг нэг цэгт тогтвортой байрлуулан дуусгадаг, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнг тусад нь байрлуулан эмчилдэг, хяналтанд тодорхой хугацаагаар байлгадаг зэрэг давуу талуудтай ч эмэнд тэсвэртэй сүрьеэ нэмэгдэх хандлагатай.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.





Тайлан бичсэн:

Б.Оюундарь /ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч/

Хянасан:

Б.Мягмар /ҮЗЗ-ийн дарга /